

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Г “Монгол газар гоулд” хоршооны хадгаламж, Ү  
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол газар гоулд” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Түдгэлзүүлсэн хугацаанд “Монгол газар” ХХК-д олгосон зээлийн барьцаа хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт бүртгүүлэн, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж, Хорооноос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж ажиллахыг “Монгол газар гоулд” хоршоо /Б.Чинбат/-нд үүрэг болгосугай.

3. Түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлж ажиллаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг “Монгол газар гоулд” хоршоо /Б.Чинбат/-нд анхааруулсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН